

**МОНГОЛ УЛСЫН  
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 16/2021

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 4.8, 4.8.1, 4.8.2, 4.8.6 дахь заалт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн 21/07/02 дугаар тогтоолыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1."Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын нэрэмжит судалгааны тэтгэлэг олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс мөрдөж ажиллахыг бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга (А.Шийрэвнямба) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тэтгэмж олгоход шаардагдах төсвийг сургуулийн жил бүрийн зардлын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засаг хариуцсан дэд захирал (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

4.Журмын хэрэгжилтэд, хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал (Б.Дамдиндорж)-д даалгасугай.


ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ХҮРЭЛБААТАР

3350210205

АШУҮИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2021 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн  
11/2021 дугаар тушаалын хавсралт



## АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН НЭРЭМЖИТ СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн (цаашид АШУҮИС гэх) магистр, докторын сургалтад амжилттай суралцаж буй суралцагсдын судалгааны ажлыг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг нэмэгдүүлэх зорилготой “АШУҮИС-ийн захирлын нэрэмжит судалгааны тэтгэлэг”-ийг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Судалгааны ажил нь АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, судалгааны ба мэргэжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцсэн байна.

### Хоёр. Тэтгэлгийн зориулалт ба хэмжээ

2.1. Тэтгэлгийг дараах зориулалтаар олгоно. Үүнд:

2.1.1. Судалгааны ажилд нэн шаардлагатай лабораторийн урвалж бодис, багаж

хэрэгсэл, программ худалдан авах.

2.1.2. Суралцагч нь судалгааны үр дүнгээрээ АШУҮИС-ийн нэр дээр 1-р зохиогчоор, Pubmed, Scopus, Web of Science мэдээллийн санд бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэхийг зөвшөөрсөн эрдэм шинжилгээний өгүүлэлд хэвлүүлэх.

2.2. Тэтгэлгийн хэмжээ магистрын танхимын суралцагчид гурван сая хүртэл төгрөг, докторын суралцагчид таван сая төгрөг хүртэл байна.

2.3. Нэг хичээлийн жилд магистр, докторын сургалтын 50 хүртэл суралцагсдад тэтгэлэг олгоно.

2.4. Суралцагч суралцах хугацаандаа тус тэтгэлэгт зөвхөн нэг удаа хамрагдана.

### Гурав. Тэтгэлэг хүсэгчид тавигдах шаардлага

3.1. Тэтгэлэг хүсэгч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

3.1.1. АШУҮИС-ийн магистр, докторын сургалтад хөтөлбөрийн төлөвлөгөөний

дагуу хоёроос дээш улирал, 10-аас дээш багц цагийн хичээлийг 3.4 ба түүнээс дээш голч дүнтэй суралцсан Монгол Улсын иргэн байх.

3.1.2. АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу өөрийн судалгааны ажлын сэдэв, арга аргачлалыг батлуулж,

ёс зүйн зөвшөөрөл авсан, судалгааны ажлаа идэвхтэй хийж буй суралцагч байх.

3.2.Суралцагч нь сургууль, тэнхим, хөтөлбөр хооронд шилжиж байгаагүй, жилийн чөлөө аваагүй байх.

3.3.Судалгааг АШУҮИС-ийн судалгааны хүрээлэн, лаборатори, эмнэлгийг түшиглэн хийх.

3.4.Суралцагчийн харьяалах тэнхим эсвэл профессорын баг тэтгэлэгт хамрагдахыг дэмжсэн байх.

3.5.АШУҮИС-ийн дүрэм, журам зөрчиж, сануулга авч байгаагүй байх.

### **Дөрөв. Бүрдүүлэх материал**

4.1.Тэтгэлэгт хамрагдахаар хүсэлт гаргаж буй суралцагч нь дараах материалыг бүрдүүлэн Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар (цаашид ТСБЗГ гэх)-т хүргэнэ.Үүнд:

1.Тэтгэлэг хүсэгчийн анкет (журмын хавсралт 1)

2.Иргэний үнэмлэхийн хуулбар

3.Голч дүнгийн тодорхойлолт

4.Судалгааны ажлын танилцуулга (АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, судалгааны ба мэргэжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцсэн эсэх, судалгааны ажлын шинэлэг тал,судалгааны ач холбогдол, явц зэргийг дэлгэрэнгүй тусгасан)

5.Удирдагч багшийн тодорхойлолт

6.Харьяалах тэнхим ба профессорын багийн дэмжсэн тодорхойлолт

7.АШУҮИС-ийн хүрээлэнгийн захирал,лабораторийн эрхлэгч, эмнэлгийн даргын тодорхойлолт

8.Хөндлөнгийн хянан магадалгаа хийгддэг олон улсын мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэхийг зөвшөөрсөн албан бичиг

4.2.Тэтгэлгийн материалыг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд ТСБЗГхүлээн авна.

### **Тав. Сонгон шалгаруулалт ба гардуулалт**

5.1.Тэтгэлгийг АШУҮИС-ийн судалгааны болон мэргэжлийн тэргүүлэх чиглэл, судалгааны ажлын төлөвлөлт, явцын үр дүн, ач холбогдол, шинэлэг тал зэргийг харгалзан сонгон шалгаруулна.

5.2.АШУҮИС-ийн захирлын тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тэтгэлэгт хамрагдах суралцагчийг сонгон шалгаруулна.



5.3.ТСБЗГ сонгон шалгаруулалтын үр дүнгээр шалгарсан тэтгэлэг авах суралцагсдын нэрсийг АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

5.4.Тэтгэлгийг бэлэн бусаар олгоно.

5.5.Суралцагч сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлсэн бол энэхүү тэтгэлгийг хөнгөлөлтийн хэмжээнээс хамаарч хувиар тооцон олгоно.

5.6.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг жилд хоёр удаа зохион байгуулж, тэтгэлгийг АШУҮИС-ийн захирал гардуулна.

### **Зургаа. Тэтгэлгийн хяналт,тайлан**

6.1.Суралцагчийн удирдагч багш нь тэтгэлгийн зарцуулалт болон тайлан өгөхөд хяналт тавьж Шинжлэх ухаан технологийн газраар (ШУТГ) баталгаажуулан ТСБЗГ-т хүлээлгэн өгнө.

6.2.Суралцагч холбогдох санхүүгийн баримтыг (урвалж бодисын төлбөр, өгүүлэл хэвлүүлэх зардал гэх мэт) бүрдүүлэн СЭЗГ-аар хянуулж, судалгааны үр дүнгээр хэвлүүлсэн өгүүлэл, хугацаандаа сургалтаа дуусгасан тодорхойлолтыг ТСБЗГ-т ирүүлнэ.

6.3.Тэтгэлгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдолд буцаан төлүүлнэ.

### Тэтгэлэг хүсэгчийн анкет

#### 1. Мэдээллийн хэсэг

##### Хувийн мэдээлэл

Овог:

Нэр:

Нас:

Хүйс:

Регистрийн дугаар:

Яаралтай үед холбоо барих утасны дугаар:

Мэргэжил:

Ажлын газар:

Албан тушаал:

##### Үндсэн мэдээлэл

Сургалт: Доктор/Магистр

Элссэн он:

Дамжаа:

Суралцаж буй чиглэл:

Удирдагч багш:

Сургууль, тэнхим:

Голч дүн:


Боловсрол:

Бакалаврын дипломын дугаар:

Магистрын дипломын дугаар:

Судалгааны ажлын сэдэв:

Хамрагдаж байсан тэтгэлэг:



## Тэтгэлгийн асуултын хэсэг (эссэ хэлбэрээр бичнэ үү)

- 1.Өмнө хийж байсан судалгааны ажлын туршлагаасаа хуваалцана уу(250 үгэнд багтаана уу)
- 2.Таны судалгааны үндэслэл, зорилго(250 үгэнд багтаана уу)
- 3.Таныг сонгож тэтгэлэг олгох шалтгааныг тайлбарлана уу.(250 үгэнд багтаана уу)
- 4.Ирээдүйн ажил, мэргэжлийн төлөвлөгөөгөө танилцуулна уу.(250 үгэнд багтаана уу)